


Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

“Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж”, түүнийг хэрэгжүүлэх нэгдсэн зохицуулалтын эрх зүйн хүрээнд Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-ыг хэрэгжүүлэх гадаад харилцааг өргөжүүлэх бодлого баримтлан ажиллалаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд гадаад харилцааг өргөжүүлэх, аймаг орны нэр хүндийг бүс нутгийн төдийгүй, олон улсын хэмжээнд өсгөж, байр сууриа бэхжүүлэн, орон нутгийнхаа хөгжилд түлхэц өгөхөд нөөц бололцоогоо чиглүүлэн ажиллав.

Тайлангийн хугацаанд ХБНГУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, Франц улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд зэрэг гадаадын нэр хүндтэй зочид, төлөөлөгчид Ховд аймагт айлчлав.

ХБНГУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Герхард Тийдеманн, Швейцарийн болон Германы хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй эрчим хүчний хэмнэлтийн төслийн явц, зохистой дулаан тусгаарлагч болон халаалтын хэмнэлттэй шийдлээр засварласан цэцэрлэгийн барилгатай газар дээр нь танилцлаа.



Франц улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Булган сумын удирдлагуудтай ажил хэргийн уулзалт хийж, 2 дугаар дунд сургуульд хандивласан компьютерийн анги танхим, хүүхдийн цэцэрлэгт хэрэгжүүлсэн худгийн төсөл, 45 ш эко 00-ийн төслийн үр дүнтэй танилцлаа.



Францын Рубрук хотын Захиргаанаас Булган сумын 2 дугаар дунд сургууль дээр зарласан “Хүүхэлдэй урлахуй уралдааныг дүгнэж Элчин сайд гарын бэлгээ гардуулав. Хүүхдүүд өөрсдийн хийсэн хүүхэлдэйгээ Рубрук хотын музейд илгээж байсан нь хамтын ажиллагаа энгийн хэлбэрээр үр дүнтэй өргөжиж байгаагийн тод жишээ боллоо

Аймгийн засаг дарга Гадаад харилцааны сайдын айлчлал, “Китай-еврази-Экспо-2014” үзэсгэлэнд оролцох ажлаар БНХАУ-ын ШУӨЗОронд 2 удаа, АНУ-д албан томилолтоор ажиллахдаа Харрисонбург хот болон Глобал их сургууль, Ховд их сургуулийн хооронд хамтран ажиллах эхлэлийг тавьж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.



Калифорни мужийн Вүүдсайд хотын Иргэдийн хурлын дарга, Станфордын их сургуулийн профессор Дебра Гордон Ховд аймагт хоёр дахь удаагаа айлчлахдаа эгч дүүс хотын тунхагт гарын үсэг зурж, Прогресс дунд сургуулийг өөрийн хотынхоо нэрэмжит болгох санал тавьж сургалтын техник хэрэгсэл бэлэглэв.

Засаг даргын орлогч М.Амарсанаа БНКазахстан улсад “Алтай бидний нийтийн гэр” олон улсын зохицуулах зөвлөлийн ээлжит 14-р хуралдаанд оролцож 2015 оны ажлын төлөвлөгөөг баталж тус хуралдаанаас 15 дугаар хуралдааныг 2016 онд Ховд хотод зохион байгуулах шийдвэр гарлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батмөнх ОХУ-ын Алтайн БНУлсад «Соёл иргэшлийн харилцаанд хүн байгаль, нийгмийн харилцан шүтэлцээ» олон улсын форумд “Аймгийн өнөөгийн хөгжилт, цаашдын зорилт” сэдэвт илтгэл тавьж оролцлоо.

Аймгийн Засаг дарга Д.Цэвээнраавдангийн урилгаар БНХАУ-ын ШУӨЗОрны Алтай аймгийн намын дарга Дэн Жан Ву, ШУӨЗОрны Хами аймаг, Шинжааны Бейтун хотын дарга Миземхан, Хятадын Сычуайн, Шанхай, Бээжин зэрэг хотуудын хөрөнгө оруулагчид, ОХУ-ын Алтайн хязгаар, Алтайн БНУ, Красноярск муж, БНТува, БНКазахстан улсын төлөөлөгчдийн 10 гаруй айлчлал, арга хэмжээг зохион байгууллаа.

Алтайн хязгаар, Ховд аймгийн хооронд хамтран ажиллах санамж бичгийн дагуу 2014-2015 оны хичээлийн жилд хөдөө аж ахуй, барилга, багшийн коллежид 6 оюутан хязгаарын тэтгэлэгт хамрагдан, сар бүр 100.000 төгрөгийн цалинтай суралцаж байна.

Жаргалант сумын 2 дугаар дунд сургууль, ОХУ-ын Алтайн хязгаарын Барнаул хотын 74 дүгээр дунд сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын тэтгэлгээр Япон улсад 2, ОХУулсад 4, БНХАУулсын их дээд сургуульд 2 багш аспирантурт суралцаж, БНХАУулсад 2 багш докторын зэрэг амжилттай хамгаалав. Түүнчлэн Швейцарь, Япон, Тайвань, Вьетнам зэрэг оронд төрийн албан хаагчид мэргэжил дээшлүүлэв.

“Галдан бошигт судлал”, “Баруун Монгол, түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, нөөц, ард түмний хэл, түүх соёл”, “Хэл, соёл, хоёл хоорондын харилцаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлуудад ОХУ, БНХАУ, АНУ, Япон, Солонгос, Норвеги, Швейцарь зэрэг орны их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн багш, судлаачид оролцлоо.

Бүсийн оношлогоо, эмчилгээний төвд Дэлхийн банк, Европын холбооны санхүүжилтээр “Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд лаборатори байгуулж, эмч, лаборантуудын мэргэжлийг дээшлүүлэн, халдварт өвчнөөс сэргийлэх тандалт судалгааг хамтран хийж байна.

Америкийн “Virtue Fandutoin” сангийн нүдний эмч нар 532 иргэнд үзлэг, 145 хүнд нүдний хагалгаа, Францын мэс заслын эмч нар 60 хүнд үзлэг, 6 хүүхдэд түлэнхийн хагалгаа, Австралийн эмч нар 2 хүнд эмэгтэйчүүдийн дурангийн хагалгаа хийж эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулахад тодорхой дэмжлэг үзүүллээ.

Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран нүүдэлчдийн соёлын өвийг хадгалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, гар урлал, бэлэг дурсгалын зүйлийг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулсан эсгий, эсгий урлалын мастеруудын олон улсын семинарыг Ховд хотод зохион байгуулахад Говь-Алтай аймаг, ОХУ-ын Алтайн БНУлс, БНТыва улсын мастерууд оролцож, Алтайн БНУ-д зохион байгуулсан семинарт оролцон туршлага судлав.

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН

ХЭЛТЭС